

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 5-р сарын 10-ны өдөр

Дугаар 03/21

Улаанбаатар хот

Компанийн удирдлагын зардлыг
батлах тухай

“Компанийн тухай хууль”-ийн 63.1.13 дугаар зүйл, хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоол, хувьцаа эзэмшигчдийн хурлын 01.21 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 3 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн удирдлагын зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244349 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар 1,680,000 төгрөг /Нэг сая зургаан зуун наян мянга/-өөр хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсөвт багтаан компанийн удирдлагын зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д.Мөнхбат/-д, зардлын зөрцуулалтын үнэн зөв байдалд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Адам Холдворд/-д тус тус даалгасугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Цолмон

Э.Тогосмаа

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 5-р сарын 10-ны өдөр

Дугаар 02/21

Улаанбаатар хот

Компанийн удирдлагыг сонгож
батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дугаар заалт, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 01/21 тоот тогтоол, ХЭХ-ын 01/21 тоот тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244349 санал буюу кумулятив 16,7%-ийн саналаар Адам Холдсвортыг, 244349 санал буюу кумулятив 16,7%-ийн саналаар С.Мөнхжаргалыг, 244349 санал буюу кумулятив 16,7%-ийн саналаар Х.Эрдэнэбаярыг, 244349 санал буюу кумулятив 16,7%-ийн саналаар С.Алимааг, 244349 санал буюу кумулятив 16,7 %-ийн саналаар Ц.Цэнгэлбаярыг, 244349 санал буюу кумулятив 16,7%-ийн саналаар П.Оюунбаярыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүнээр сонгосныг баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244349 санал буюу кумулятив 33,3%-ийн саналаар Х.Оюунгэрэлийг, 244349 санал буюу кумулятив 33,3%-ийн саналаар И.Сэр-Одыг, 244349 санал буюу кумулятив 33,3%-ийн саналаар Л.Бүрэнтэгшийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосныг баталсугай.
3. “Компанийн тухай хууль”-ийн 76 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, компанийн үйл ажиллагааг удирдлага хяналтаар хангаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Адам Холдсворт/-д зөвшөөрсүгэй.

Хурлын дарга



Б.Цолмон

Тооллогын комиссын дарга



Э.Тогосмаа

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 5-р сарын 10-ны өдөр

Дугаар 01/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн саналын
дүнг батлах тухай

Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 63 дугаар зүйл, “Монноос” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 01.21 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын 244349 санал буюу ердийн олонхийн 100-ийн саналаар Компанийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны талаарх гүйцэтгэх захирлын тайланг, 244349 санал буюу ердийн олонхийн 100%-ийн саналаар Компанийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг тус тус баталсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, “Компанийн тухай хууль”-ийн 83 дугаар зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, ТУЗ-д ажлаа дүгнүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Д.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

Хурлын дарга

Тооллогын комиссын дарга



Б.Цолмон

Э.Тогосмаа